

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны IV улирлын тойм мэдээ

МАНАЙ ҮНДСЭН ЗОРИЛГО

Дэлхийд тэргүүлэх, аюулгүй, тогтвортой зэсийн бизнесийг хамтдаа цогцлоож, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах

МАНАЙ АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ



- 2025 онд “Оюу толгой” компани нийт 2.34 их наяд төгрөгийг татвар хураамж, бусад төлбөрт төлсөн нь Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын* ойролцоогоор 9%-ийг бүрдүүлсэн байна.
- Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд өнгөрөгч онд нийт 8.4 их наяд төгрөг төлснөөр Монгол Улсад өдөр бүр 23 тэрбум төгрөгийг зарцуулан, эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.
- Өнгөрөгч онд олон улсын зах зээл дэх зэс, алтны үнийн өсөлтөөс шалтгаалан компанийн чөлөөт мөнгөн урсгал төлөвлөсөн хэмжээнээс хоёр дахин давсан гүйцэтгэлтэй байлаа.

* Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо - Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээлэл

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зорилт
*0.23-аас бага байлгах

Гүйцэтгэл

0.22

2025 оны дөрөвдүгээр улиралд гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.16 ноогдож байгаа нь Рио Тинто болон дэлхийн ижил төстэй уурхайнуудтай харьцуулахад хамгийн аюулгүй уурхайн нэгд тооцогдох үзүүлэлт юм.

МОНГОЛ АЖИЛЧДЫН ХУВЬ

Хөрөнгө оруулалтын
гэрээгээр хүлээсэн үүрэг 90%

97.7%

ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

Оюу толгойн стратегийн
зорилт 25%

24.2%

БОЛОВСРОЛ, ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

“Оюу толгой” компани ирээдүйн чадварлаг уурхайчид, инженерүүд, салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хувь нэмрээ тууштай оруулсаар байна.



УЛСЫН ХЭМЖЭЭНД

2010 оноос хойш 2,323 сурагч/оюутан Залуусын хөгжлийн хөтөлбөр, Дотоодын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдлаа.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД

2016 оноос хойш 855 оюутан Говийн оюу оюутны тэтгэлэг, Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хамрагдлаа.



КАРЬЕР ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

2013 оноос хойш 1,617 сурагч/оюутан Шинэ төгсөгчийн хөтөлбөр, Дадлагын болон Дадлагажигч хөтөлбөр, Ажил, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдлаа.

Манай ажлын үзүүлэлт, 2025 оны IV улирлын тойм мэдээ




Оюу толгойн уурхай дахь
Мэргэжил сургалтын төв



ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(2025, IV УЛИРАЛ)



2011 оноос хойш Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд нийт 482,8 тэрбум төгрөгийн* хөрөнгө оруулалтыг хийжээ.

Боловсрол	206.4 сая төгрөг
Байгаль орчин	30 сая төгрөг
Түүх соёл	66.2 сая төгрөг
Эрүүл мэнд, сайн сайхан байдал	30 сая төгрөг
Дэд бүтэц	10.8 тэрбум төгрөг
Орон нутгийн бизнесийн хөгжил	2.1 тэрбум төгрөг
Спорт цогцолбор	11.1 тэрбум төгрөг

* Өмнөх тайлангууд “Оюу толгой” компанийн орон нутагт оруулсан зарим хөрөнгө оруулалтыг хамруулаагүй болно.

Манай ажлын үзүүлэлт
2025 оны IV улирлын тойм мэдээ



Оюу толгойн хөрөнгө оруулалттай Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр Өмнөговь аймгийн Даланзадгад суманд баригдсан 33 дугаар цэцэрлэг



ТАТВАР, ХУРААМЖ,
БУСАД ТӨЛБӨР

(2025, IV УЛИРАЛ)


776

ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ

ТАТВАР ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ
ТӨЛЖЭЭ.

Татвар, хураамж, үндэсний
компаниудад төлсөн НӨАТ* зэрэг
бусад төлбөрт 14.4 их наяд төгрөг**
2010 оноос хойш төлсөн.

* “Оюу толгой” ХХК НӨАТ-ын буцаан
олголт авдаггүй.
** Энэ дүнд олон улсын арбитрт
хэлэлцэгдэж буй 1.3 их наяд төгрөгийн
татварын маргааны төлбөр багтсан
болно.



Тайлант хугацаанд Өмнөговь
аймгийн Даланзадгад суманд
үйл ажиллагаа явуулж буй “Хасуд
бат” ХХК нийт 71,400 хос аюулгүй
ажиллагааны бээлийг үйлдвэрлэн,
Оюу толгойн уурхайд нийлүүлжээ.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2025, IV УЛИРАЛ)



73%

Аж ахуй нэгж, бусад
байгууллагад төлсөн төлбөр
(НӨАТ-тай)

20%

Улс, орон нутгийн төсөвт
шууд төлсөн төлбөрүүд

7%

Цалин

Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт,
бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар,
хураамж, үндсэн ажилчдын цалинд 2010 оноос
хойш 55.8 их наяд төгрөг зарцууллаа.



ДОТООДЫН ХУДАЛДАН
АВАЛТ

(2025, IV УЛИРАЛ)

1.7 ИХ НАЯД
ТӨГРӨГ

2025 оны дөрөвдүгээр улиралд үйл
ажиллагааны худалдан авалтын баг
772 ханган нийлүүлэгчтэй хамтран
ажилласны 571 нь дотоодын ханган
нийлүүлэгчид байв. Эдгээр дотоодын
компанид худалдан авалтынхаа 87.3
хувийг зарцуулав. 2010 оноос хойш
дотоодын худалдан авалтад 39 их
наяд төгрөг зарцуулсан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ХЭМЖЭЭНД ХИЙСЭН
ХУДАЛДАН АВАЛТ

(2025, IV УЛИРАЛ)

292.1 ТЭРБУМ
ТӨГРӨГ

2025 оны дөрөвдүгээр улиралд
Өмнөговь аймагт бүртгэлтэй 105
ханган нийлүүлэгчээс 292.1 тэрбум
төгрөгийн бараа, үйлчилгээ авлаа.
2010 оноос хойш Өмнөговь аймгаас
нийт 6.1 их наяд төгрөгийн бараа,
үйлчилгээ авчээ.



ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2025, IV УЛИРАЛ)

6.8
ТЭРБУМ ТӨГРӨГ




“Оюу толгой” компани Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон холбогдох гэрээнүүдийн дагуу ус ашигласны төлбөрийг бүрэн төлж ирсэн бөгөөд 2013 оноос хойш ус ашигласны төлбөрт нийт 218 тэрбум төгрөг төлсөн.

86.7%

2025 оны дөрөвдүгээр улиралд ус дахин ашиглалтын зорилт 80 хувь байсан бөгөөд зорилтоо давуулан биелүүлж, дунджаар 86.7 хувьд хүргэв.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ


(НЭГ ТОНН ХҮДЭР БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ, ШОО МЕТР, САРААР)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа 2025 оны дөрөвдүгээр улиралд нөхөн сэлбэлтээр 0.4м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХАЯГДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

(ХУВЬ, САРААР)



2025 оны дөрөвдүгээр улиралд үүссэн нийт хаягдлын дунджаар 76 хувь нь дахивар нөөц байна.



Оюу толгойн уурхай дахь үйлдвэрийн усыг дахин ашиглах зорилгоор лагийг өтгөрүүлэн, усыг ялгах байгууламж



ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

100
САЯ МОД
Өвчлэн үлдээ


ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАРААХ АЖЛУУДЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ:

- Тус хөтөлбөрийн зөвлөх ойн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгууллаа.
- Хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг Эрдэнэс Оюу Толгой, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газар зэрэг холбогдох талуудад хүргүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд нийт 36.4 сая модыг дүйцүүлэх болон шууд хэлбэрээр тарьж ургуулаад байна.
- 2022 оноос хойш Сэлэнгэ болон Дархан-Уул аймгийн нутагт хариуцлагагүй уул уурхайн нөлөөгөөр эвдэрч, орхигдсон нийт 1,215 га талбайд газрын нөхөн сэргээлт хийгээд байна.



Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Цагаан зүрийн гол орчимд “Оюу толгой” компанийн нөхөн сэргээлт хийсэн талбай

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Оюу толгойн уурхай
дахь хүдэр агуулах
байгууламж


Манай ажлын үзүүлэлт, 2025 оны IV улирлын тойм мэдээ



ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(мян.тонн)



Зорилт (97.8 тонн,
дөрөвдүгээр
улиралд)

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ

(мян.унц)



Зорилт (143.8
мянган унц,
дөрөвдүгээр
улиралд)



- Дөрөвдүгээр улирлын турш зэсийн үйлдвэрлэл өндөр үзүүлэлттэй байсан бөгөөд 12 дугаар сард дээд амжилт тогтоосон. Түүнчлэн ил уурхайн тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдал, баяжмал үйлдвэрлэл, тээвэр, ложистикийн гүйцэтгэл амжилттай сайн байсан. 12 дугаар сард алт болон зэсийн метал авалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлэв.
- Гүний уурхайн олборлолт хоногт 52 мянган тоннд хүрч дээд амжилт тогтоон, 12 дугаар сарын дундаж олборлолт хоногт 42 мянган тонн болж өссөн өндөр гүйцэтгэлтэй байлаа. Панел 2-ын хойд хэсгийн бүтээн байгуулалт тогтвортой урагшилж, дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 6 хүдэр буулгуурыг тэсэллээ.
- Гүний уурхайн Хоёрдугаар анхдагч бутлуур болон Баяжуулах үйлдвэрийн Тавдугаар бөмбөлөгт тээрмийг Улсын комиссд хүлээлгэн өгч, ашиглалтад оруулснаар зэсийн үйлдвэрлэлийн өсөлтөд эерэгээр нөлөөлсөн.